

**Их Эзэн надаас золиос гаргахыг хүсвэл би итгэлтэйгээр дагаж чадна (1 Хаад 17:8-16).**

Зарефатын бэлэвсэн эмэгтэй, бошиглогч Елиа хоёрын зургийг будаад, хайчлаарай. Дараа нь өөр цаас ашиглан, торхноос арай томхон тэгш өнцөг хэлбэртэй дүрс хайчлан, үүнийгээ торхны харалдаа зургийн ар талд наа. (Тэгш өнцөгт хэлбэртэй дүрсээ дөрвөн талд нь наана.) Торхон дээрх тасархай шугамуудын дагуу зүсэж, онгойлгоно. Дараа нь итгэлээ нэмэгдүүлэхийн тулд хийж чадах зүйлсээ цаасан дээр бичиж эсвэл зураарай. Эдгээр цаасаа торхонд хийгээд,

буцааж наа.

